


**БУМАН**  
**ДУСАЛ** БАНК БҮС  
САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГА

Гүйцэтгэх захирлын  
2026 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн  
А/20 тоот тушаалаар батлав. Хавсралт 1



**“БУМАНДУСАЛ ББСБ” ХХК-НЫ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
БОДЛОГО**



Хамрах хүрээ: “БУМАНДУСАЛ ББСБ” ХХК-нийт ажилтнууд болон оролцогч талууд	Хариуцах эзэн: Хүний нөөц
Хувийг хадгалах: Цахимаар болон биетээр	Танилцах: ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, нийт ажилтнууд
Хамрах хугацаа:	Хуудасны тоо 6
Боловсруулсан:	МАБ-н баг
Хянасан:	Гүйцэтгэх захиарал
Мэдээллийн ангилал	Дотоод

Өөрчлөлтийн түүх

	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1.	1	2026.04.15	Анхны хувилбар
2.			
3.			
4.			
5.			

## НЭГ. ЗОРИЛГО

- 1.1 Мэдээллийн аюулгүй байдлын бодлого нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Байгууллага нууцын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна.
- 1.2 Биет болон биет бус мэдээллүүд эдгээртэй ажиллаж байгаа бүх ажилтан, харилцагч байгууллагууд энэхүү бодлогын баримт бичгийг дагаж мөрдөнө.

## ХОЁР. БОДЛОГО

- 2.1 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны бодлого  
Бумандусал ББСБ"ХХК-ын стратегийн зорилго зорилттой нийцсэн, тэдгээрийн харилцагчийн мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал, бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоог бий болгох арга замаар мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулна
- 2.2 Баримт бичгийн хариуцагч нь энэхүү баримт бичгийг жилд нэг удаа эсвэл шаардлага гарсан тухай бүрд эзэмшигчийн зөвшөөрлөөр шинэчлэн сайжруулна.
- 2.3 Байгууллага нь МАБ-ын бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд МАБ-н зорилтуудыг тухайн оны эхний улиралд багтаан тодорхойлж, удирдлагаар батлуулан, хэрэгжилтийг Удирдлагын дүн шинжилгээний хурлаар хэлэлцүүлэн, шаардлагатай өөрчлөлтийг тусган шинэчилдэг байна.
- 2.4 Энэхүү бодлого нь байгууллагын бүх ажилтан, сонирхогч тал, оролцогч тал зэрэг байгууллагын бүхий л үйл ажиллагаатай холбоотой бүх талуудыг мөн байгууллагын эзэмшиж буй эсвэл удирддаг бүх мэдээллийн систем, сүлжээ, өгөгдлийг хамарна.
- 2.5 Баримт бичгийн хариуцагч нь энэхүү баримт бичгийг жилд нэг удаа эсвэл шаардлага гарсан тухай бүрд эзэмшигчийн зөвшөөрлөөр шинэчлэн сайжруулна.

## ГУРАВ. МАБМТ-ны хамрах хүрээ

### 3.1. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хамрах хүрээ

Бид байгууллагын үйл ажиллагаанд Мэдээллийн Аюулгүй Байдлын Менежментийн Тогтолцоог (цаашид МАБМТ гэх) бий болгон тогтвортой мөрдөн, тасралтгүй сайжруулах зорилгоор ISO стандартыг дараах хамрах хүрээнд хэрэгжүүлэн ажиллана.

### 3.2 Хамрах бүтээгдэхүүн, үйл ажиллагаа

Зээлийн үйл ажиллагаа

### 3.3 Хамрах газар нэгжүүд

Санхүүгийн газар

Хууль эрсдэл, комплаенсын газар

Зээлийн газар

Дотоод хяналтын газар

Үйл ажиллагааны газар

### 3.4 Хамрах биет байршил

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо 6 хороолол /15140/ Тусгаар тогтнолын талбай 7 давхар 705 тоот

### 3.5 Хамаарахгүй хэсгүүд


22 автохүрээ салбар

Соёолж салбар

Да хүрээ салбар

Эрдэнэт салбар

### 3.6 Салбар нэгжүүд



#### ДӨРӨВ. ХАРИЛЦАА

4.1 Энэхүү бодлого нь МАБМТ-ны хамрах хүрээний бүхий л оролцогч талуудтай хэзээ хэрхэн холбогдохыг тодорхойлсон байна.

4.2 Мэдээлэл, мэдээллийн систем, дэд бүтэц, программ хангамж, мэдээллийн сүлжээ, түүнчлэн мэдээлэл боловсруулах аппликэйшн, хадгалах өгөгдлийн сан зэрэгт нууцлал, бүрэн бүтэн болон хүртээмжтэй байдалд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээг тогтмол хугацаанд хийнэ.

4.3 Мэдээллийн аюулгүй байдлын зөрчил гарах /мэдээлэл задруулах, халдлагад өртөх, луйвар гарах, гэнэтийн осол, давагдашгүй хүчин зүйлс тохиолдох/ үед үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах бөгөөд тайлагналын механизмыг хэрэгжүүлж, ирээдүйд дахин давтагдахаас сэргийлж үндсэн шалтгаанд суурилсан дүн шинжилгээ хийдэг байна.

4.4. Ханган нийлүүлэгчид болон бусад сонирхогч талуудад шаардлагатай үед МАБМТ-ны баримт бичгийг хүртээмжтэй байлгана.

#### ТАВ. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАСАГЛАЛЫН ПРОЦЕСС

5.1 Мэдээллийн аюулгүй байдлын засаглал нь дараах үндсэн дөрвөн процесс байна. Үүнд:

5.1.1 Процесс1: Үнэлэх процесс нь одоогоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төлөвлөгдсөн өөрчлөлтүүд дээр үндэслэн одоогийн болон хүрэхийг зорьж буй зорилтуудад ямар зохицуулалт хийх шаардлагатайг тодорхойлдог засаглалын процесс юм

5.1.2 Процесс2: Чиглүүлэх процесс нь байгууллагын стратеги зорилтуудын тухай чиглэлийг өгдөг засаглалын процесс юм. Тухайн чиглүүлэгт байгууллагын нөөцүүдийн хуваарилалт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшин, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө багтана.

5.1.3 Процесс3: Байнгын хяналт процесс нь байгууллагын стратегийн зорилтууддаа хүрэхийг үнэлэх боломжийг олгодог засаглалын процесс юм.

- 5.1.4 Процесс4: Харилцаа процесс нь удирдах байгууллага болон сонирхогч талууд өөрсдийн хэрэгцээнд тохирсон мэдээлэл солилцдог хоёр талын засаглалын үйл явц юм.
- 5.1.5 Компанийн гүйцэтгэх удирдлага нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд бүхий л талаар дэмжиж, үр дүнтэй байдлыг хангахад дараах алхамуудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.1.6 Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, зорилтуудыг компанийн бизнес төлөвлөгөө, нөхцөл байдалтай нийцүүлж боловсруулж, батлуулна.
- 5.1.7 Мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхдээ компанийн бизнесийн болон бусад процесстэй уялдсан байна.
- 5.1.8 Мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, тогтвортой байлгах, тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг дэмжиж, шаардагдах нөөцөөр тогтмол хангана.
- 5.1.9 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, мэдээллийн аюулгүй байдал болон мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны шаардлагад нийцэх ач холбогдлын талаар тодорхой ойлголттой байна.
- 5.1.10 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог төлөвлөсөн үр дүнд нь хүргэх талаар бүхий л арга хэмжээг авч удирдлагын тогтолцоог үр дүнтэй болгоход хувь нэмрээ оруулахыг бүх ажилтнуудад уриална.

## **ЗУРГАА. ХЯНАЛТ, ХЭМЖИЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ҮНЭЛГЭЭ**

- 6.1 Байгууллагын МАБ-ын бодлого тэдгээрийн дагуу боловсруулагдсан журмуудын хэрэгжилтийг хангасан байдлыг үнэлэх зорилгоор зорилтод нийцсэн хяналт хэмжилтийг хэрэгжүүлнэ. Хяналт хэмжилтийн үр дүнг Удирдлагын дүн шинжилгээний хурлаар тайлагнаж, хэлэлцүүлж, дүн шинжилгээ хийх ба шаардлагатай өөрчлөлтийг МАБМТ-нд тусган сайжруулна.

## **ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

- 7.1 Энэхүү бодлого, түүний хүрээнд боловсруулсан журмыг зөрчсөн, сонирхогч талуудад эсрэг хуурамч мэдээлэл өгөх, эрх мэдлээ хэтрүүлэх, мэдээллийн нууцыг санаатай болон санаандгүй задруулсан, хувийн ашиг сонирхлоор асуудалд хандсан зэргээр ББСБ-д шууд болон шууд бус хохирол учруулсан ажилтныг холбогдох Монгол Улсын хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэж, учирсан хохирлыг арилгуулахаар шаардана.
- 7.2 Энэхүү бодлогыг зөрчсөн нь тогтоогдвол байгууллагын ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулж, ажлаас нь халах хүртэл арга хэмжээ авах үндэслэл болно.

## **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ**

- R (Гүйцэтгэгч)
- A (Эцсийн хариуцагч)
- C (Зөвлөлдөх)
- I (Мэдээлэх)

Бүлэг	Шаардлага	PDCA	Гол үйл ажиллагаа	Гүйцэтгэх захирал	МАБ-н баг	МАБ-н ажилтан	Нийт ажилчид
4	Байгууллагын орчин	P	Score, сонирхогч талууд тодорхойлох	A	R	C	I
4.4	ISMS бий болгох	P	ISMS бүтэц, процесс тодорхойлох	A	R	C	I
5	Удирдлага	P	Бодлого батлах, үүрэг хуваарилах	A	R	C	I
6	Төлөвлөлт	P	Эрсдэлийн үнэлгээ, боловсруулалт	A	R	C	I
6	Төлөвлөлт	P	ISMS зорилго тогтоох	A	R	C	I
7	Дэмжлэг	D	Сургалт, мэдлэг нэмэгдүүлэх	A	R	C	I
7	Дэмжлэг	D	Баримт бичгийн удирдлага	A	R	C	I
8	Үйл ажиллагаа	D	Эрсдэлийн үнэлгээ хэрэгжүүлэх	A	R	C	I
8	Үйл ажиллагаа	D	Хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх	A	C	R	I
8	Үйл ажиллагаа	D	Инцидент/зөрчлийн удирдлага	A	C	R	I
8	Үйл ажиллагаа	D	Өөрчлөлтийн удирдлага	A	C	R	I
9	Үнэлгээ	Ch	Хяналт, хэмжилт хийх	A	R	C	I
9.2	Дотоод аудит	Ch	Аудит хийх	A	R	C	I
9.3	Удирдлагын үнэлгээ	Ch	Удирдлагын дүн шинжилгээ	A	R	C	I
10	Сайжруулалт	A	Зөрчил, Үл тохирол залруулах	A	R	C	I
10	Сайжруулалт	A	Тасралтгүй сайжруулалт	A	R	C	I